

Living the Lotus

Buddhism in Everyday Life

New Year's Issue



2025 оны айлдвар

Цоо шинэхэн жил

**Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо**



**Хүн бэлдэх нэн чухал.
Байгууллагын 100 жилийн ойг
зорин бурхны үйлд хичээнгүйлэн
шамдацгаая.**

Та бүхэнд шинэ оны мэнд хүргэе.

Шинэ жилийн эхний өдөр бол төрөөд анх удаа учран золгож буй нандин чухал өдөр гэж хэлж болно. Хэдэн нас хүрсэн ч бай өнөөдрөөс хойших өдөр бүхэн өмнө учирч байгаагүй шинэ амьдрал юм.

«Их Эрдэм» хэмээх Хятадын эртний судар бичигт “Нэг өдрийг шинээр эхлүүл, дараагийн өдрийг ч бас. Энэ мэтчилэн өдөр бүрийг шинээр эхэл.” гэх сургаал үг байдаг.

Эртний Хятадын нэгэн мэргэн ухаантан гар нүүрээ угаадаг төмпөн дээрээ энэ үгийг сийлээд өдөр бүр уншин дуудаж өөрийгөө цэгнэдэг байсан гэдэг.

Бид бүхэн ч гэсэн энэ жил өдөр бүрийг цоо шинэ сэтгэлээр угтаж, бурхны зам мөрөөр өөдрөг эрч хүчтэй алхацгаая.



Ингээд миний бие өнгөрсөн 11-р сард болсон байгууллагын удирдлагын хурлаар дараах “Байгууллагын 2025 оны чиг шугам”-ыг танилцуулсан.

“Хүн одоогийн байдалдаа сэтгэл ханалгүй эрхэм дээд аугаа зүйлийг эрэлхийлэн замнах ахуйд тэнд хүндлэн дээдлэх сэтгэл бий болдог. Уг хүндлэх сэтгэл хөгжөөд ирэхээр дараагийн шатанд дутуу дулимаг өөрийгөө олж харж, түүнээсээ ичих сэтгэл төрнө. Хүн өсөж хөгжихөд нэн чухал хүчин зүйл бол хүндлэн дээдлэх сэтгэлээ хөгжүүлэх хийгээд ичихийг мэдэх сэтгэл болно.”

Дээр өгүүлсэн мэргэн ухаантны онч үгэнд агуулагдах чухал сэтгэлийг санаж, энэ жил ч гэсэн бид бүхэн сүсэг бишрэл бүхий амьдралаар дамжуулан эхнэр нөхөр, ээж аав, эцэг эхийн хувиар ирээдүйг бүтээх хүүхэд залууст хүнлэг зам мөрийг заан сургаж, хүнлэг хүнийг өсгөн хүмүүжүүлж, өрх гэрээ засан товхинуулж, улс орныхоо өв уламжлал ёс заншлыг залгамжлан сайн сайхан улсыг бий болгохын төлөө өдөр бүр өөдрөг тэмүүлээр хичээн зүтгэцгээе.

Энэ жилийн зорилт урд жилийнхээс бараг өөрчлөгдөөгүй хэдий ч байгууллагын гишүүний хувиар бид үүнийг ямагт санаж явбал зохилтой.

Өнөөг хүртэл би “хүн бэлдэх (өсгөн хүмүүжүүлэх)” хэмээх үндсэн асуудалд анхаарал хандуулж, түүний төлөө хувь нэмэр оруулцгаая гэж уриалж ирсэн.

Эртний Хятадын гүн ухааны сударт

“Нэг жилийн төлөвлөгөө бол тариа тарих нь зүйтэй. Арван жилийн төлөвлөгөө бол мод тарих нь зүйтэй. Нэгэн насны төлөвлөгөө бол хүн бэлдэхээс өөр чухал зүйл үгүй.” хэмээх сургаал бий. Сайн сайхан нийгэм, улс орон, дэлхий ертөнцийг бүтээе гэвэл хүн бэлдэхээс өөр чухал зүйл үгүй гэсэн утгатай.

Үүний хамгийн чухал суурь нь гэр бүлийн хүмүүжил байдаг. Өрх гэрээ товхинуулан гэр бүлийн хүмүүжлийг сайн тавьж өгснөөр сургуулийн боловсролын үр өгөөж сайжирч, жинхэнэ утгаараа “хүн бэлдэх” гэсэн цогц зүйл бий болдог.

Дорнын гүн ухааны төлөөлөгч хэмээн танигдсан Ясүока Масахиро гуайн номонд дараах мөрт байдаг. “Гэр бүлийн орчин бол хүүхэд үрслэн соёолох суурь хөрс тул үр хүүхдийнхээ хувьд эцэг нь хүндлэн дээдлэх оршихуй, эх нь энэрэл хайрын оршихуй байвал зохино.” Тариа будааг үрслүүлэх хөрс шороо сайнгүй бол намар ургац авах тухай бодоод хэрэггүй буй за.

Энэхүү хүн бэлдэх суурь үүргийг амьдралын туршлага арвин эхнэр нөхөр (залуу үе), ээж аав(дунд насныхан), эцэг эх (өвөө эмээ) нар хариуцлагатайгаар биелүүлснээр хүүхэд залуус аяндаа хүнлэг мөн чанартай хүн болж өсөж хүмүүждэг. Байгууллагын 100 жилийн ойг зорин үүнийг онцгойлон анхаарья гэж бодож байна.

Шоотокү хунтайж (574–622) “17 зүйлт үндсэн хууль”-ийн 1-р зүйлд “Эв нэгдэл хамгаас эрхэм.” гэж заасан байдаг. Мөн эртнээс эдүгээг хүртэл Япон улсын суурь үзэл санаа “агуу энх тайван”, “агуу эв нэгдэл” байсаар ирснийг Япон улсыг “Ямато” (агуу эв нэгдэл) гэж нэрлэдэг байсан түүх илтгэнэ. Энэхүү уламжлалт сэтгэлгээг дэлхий дахинд ч хүлээн зөвшөөрдөг ба үүнийг бодитоор хэрэгжүүлэхийн төлөө хичээх нь бидний том үүрэг хариуцлага юм.





“Хүндлэн дээдлэх” хэмээх ухагдахууны үндэс нь өөрийгөө хүндлэх болно.

Энэ жилийн зорилтод дурдсан “хүндлэх сэтгэл” гэдэгт том зорилготой байх, өсөн дэвших хүсэл эрмэлзэлтэй байх гэсэн утга агуулагдаж буй. Энэ нь төгс бус өөртөө сэтгэл ханалгүй, уулын оргил өөд бага ч болов дөхье гэсэн санаа юм.

Ийнхүү хүндлэх сэтгэл суугаад ирэхээр алдаа дутагдлаа анзаарч, ичих сэтгэл төрдөг ба улмаар өөртөө сахилга батыг суулгаж, дахин шинээр эхэлдэг.

Хүндлэх сэтгэлд онцгойлон чухалчилбал зохих нэг зүйл бий. Тэр бол өөрөө өөрийгөө хүндлэх юм.

Өөрийнхөө нандин чухал оршихуй болохыг ойлгоогүй хүн жинхэнэ утгаараа бусдыг хүндэлж чадахгүй. Эхлээд өөрийнхөө нандин чухлыг ойлгож мэдэрч байж бусад хүмүүсийг хайрлаж хүндэлдэг болно.

Угаас бид ховор нандин хувь зохиолоор энэ ертөнцөд мэндэлсэн. Үүнийг сурган хүмүүжүүлэгч Тоои Ёшио гуай ийнхүү илэрхийлсэн байдаг. “Өөрийнхөө хүслээр энэ ертөнцөд мэндэлсэн хүн нэгээхэн ч үгүй. Биднийг ямар нэгэн үл мэдэх хүч энэ ертөнцөд төрүүлсний ачаар бид амь нас, амьдралтай учран золгосон.” Үнэхээр гүн сэтгэгдэл төрүүлэм хүчтэй үг байгаа биз.

Үүний зэрэгцээ бид нар, сар, од, уул, гол, агаар, ус, хүмүүс, ургамал амьтан, хорхой шавьж, бичил биетэн, нян бактер гээд хамаг юмсын ачаар амьдардаг. Ийнхүү амь насныхаа эх үндсийг эргэцүүлэн бодох тусам ямар нандин, гайхамшигтай, талархмаар болохыг ухаарна.

Түүнчлэн хүн төрөлхийн бурхны гэгээрэл, туйлын үнэн зам мөрийг ухамсарлах оюун ухаантай, бурхны хутаг олох үрийг тээсэн буюу бурханлаг

мөн чанартай гэдэг.

Зовж шаналж буй нэгнийг хараад ямар нэгэн аргаар туслах юмсан гэх сэтгэл төрдөг нь бидний сэтгэлийн гүнд Бурхан лугаа адил чанар байгааг гэрчилнэ.

Бурханд залбиран мөргөх бидний дотор ч гэсэн бурханлаг сэтгэл оршиж буй. Тэгэхээр Бурханд залбиран мөргөнө гэдэг нь өөрийн дотор буй бурханлаг чанартаа мөргөж байна гэсэн үг.

Хүмүүс бид өөрийгөө “би тийм мундаг биш” гэж голдог. Гэвч үнэндээ бидний амь нас тэр чигээрээ гайхамшиг юм. Бид сэтгэлдээ Бурхан лугаа адил мөн чанарыг цогцлоосон, туйлын үнэн буюу Бурханы Номыг ойлгох оюун ухаан хийгээд асуудлыг шийдэх чадвартай. Үүнийг сэтгэл зүрхэндээ бат бөх сийлж, итгэл төгс бурхны үйлийг хэрэгжүүлэх нь Бурханы Номын дагуу амьдрах үндэс болно.

Буддизмын Соото урсгалыг үндэслэгч Зэн багш Доогэн ингэж сургасан. “Өнөөдрийн амь нас, биеэ нандигнан хайрлавал зохилтой. Бурхны зам мөрийг хэрэгжүүлж буй өөрийн бие сэтгэлийг ч гэсэн хайрлан хүндэлж байх нь зүй.”





Тиймээс бурхны зам мөрд хичээнгүйлэн суралцаж, хэрэгжүүлж буй өөрийн бие, өөрийн сэтгэлийг хүндлэн дээдлэх хэрэгтэй гэдгийг ойлгож ухамсарлахыг хүсэж байна.

Хий насаар 88 настай золгож буйг тохиолдуулан та бүхэнтэй хамт бурхны сургаалд идэвхтэй суралцаж, хэрэгжүүлэх болно.

Миний бие энэ жилийн 3-р сарын 20-нд 87 нас буюу хий насаар 88 нас хүрнэ.

Өмнө өгүүлсэнчлэн Бурханаас амь насыг хүртэж, хамаг амьтны ач буянаар эл өдөртэй золгож байгаадаа туйлын их талархах сэтгэл төрж байна.

Хүнд төрсөн эцэг эх ганц байдаг боловч өвөө эмээ, элэнц хуланц гээд 30 үеэ тоолох юм бол өвөг дээдсийн тоо даруй 1 тэрбум давна гэдэг. Төсөөлшгүй олон өвөг дээдэс маань амь насыг ганц ч тасалдуулалгүй үргэлжлүүлсний ачаар өнөөдөр би энд байгаа билээ.

Амь насны энэхүү урт замнал дунд Үүсгэн байгуулагч өөрийн амьдралыг туулж 92 насандаа нирваанд орсон. Ээж

минь ч гэсэн 85 жилийн амьдралыг үзэж туулсан. Би ч гэсэн эцэг эхийнхээ үр нь болон мэндэлж, өөрийн туулах ёстой амьдралыг туулж нас 80-ын сүүл хагас руу ороод байна. Ингээд бодохоор хүн бүр өөр өөрийн замналаар амь насыг үргэлжлүүлдэг ажээ.

Мөн хүн бүр өөрийн гэсэн онцлог чанартай. Усанд сэлэлтийн марафоноор зүйрлүүлэх юм бол араар даллаж сэлэхдээ гарамгай хүн байхад далайн гахайн сэлэлтдээ сайн хүн ч бий. Тэд багийн гишүүний хувиар өөрт оногдсон хэсгээ хамаг чадлаараа сэлж дуусгаад дараагийн хэсгийг удаах хүн буюу үр хойчдоо хариуцуулан үлдээнэ. Хүний амьдрал ийнхүү үргэлжилдэг буй за.

Нас ахихаар залуу хүн шиг сурамгай хөдөлж чадахаа байна. Хөл гар, ууц нуруу ч гэсэн сул дорой болно. Харин тархи бол ажиллах тусам сайжирдаг гэсэн.

Эдогийн сүүл үеийн Күнзийн эрдэмтэн Сатоо Иссаи багштаны дараах үг бий. “Залуудаа сурч боловсрох аваас хижээл насанд хийж чадахгүй зүйл үгүй. Хижээл насандаа сурч боловсрох аваас бие хөгширсөн ч оюуны чадвар хөгшрөхгүй. Хөгширсөн ч сурахаа үл зогсоох аваас бие үгүй болсон ч үзэл санаа, оюун санааны өв хөрөнгө үр хойчид өвлөгдөн үлдэх болой.”

Сурч боловсрох тухайд хүн зоны төлөө, дэлхийн сайн сайхны төлөөх зорилгоор сурч мэдэх нь хамгийн эрхэм.

Хүн сурч боловсроод ирэхээр дотоод сэтгэл од мэт гэрэлтэн гялалздаг гэдэг.

Тэгэхээр энэ жил ч гэсэн хамтдаа идэвхтэй сурч боловсроход анхаарч, Шагжамүни бурхны айлдан сургасан бодисадвагийн зам мөр (хүнлэг амьдрал)-өөр өөд тэмүүлэн алхацгаая.

«Косей» сонин, 2025 оны 1-р сар

